

ГУРАВДАГЧ ХӨРШ: ТӨВ АЗИД МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН БАЙР СУУРЬ БЭХЖЛЭЭ

*Дашидоржийн Баярхүү**

Титэм үг

Олон улсын тавцанд манай улсын гуравдагч хөршийн бодлого танигдсаар байна. Гуравдагч хөрш гэдэг ойлголтод шинэ шинэ бүс нутаг, улс орон нэмэгдэж байгаа нь одоо цагийн гадаад бодлогын том ололт мөн бөгөөд гуравдагч хөршүүдтэй тогтоосон түншлэл жил ирэх тусам өргөжин тэлж, түншлэлийн түвшин шат ахиж байгаа нь нэг гол онцлог юм.

Нэг. Төв Ази хэн бэ, ямар ач холбогдолтой вэ?

Төв Азийн бүс нутгийн олон талын ач холбогдол дэлхийн глобал геополитикийн их хувиралт, хувьсал, сорилтыг дагалдан шал өмнөө дүр зурагтай болсон нь олон улсын харилцааны өнөө цагийн нэг онцлог юм. Иймд тус бүс нутгийн геополитикийн ач холбогдлыг авч үзэхдээ хэд хэдэн хүчин зүйл, олон талт үйл явцын өнцгийг орхигдуулж үл болно.

Төв Ази өнөөдөр хэн бэ гэдгээсээ илүүтэй дэлхийн бодлого тодорхойлдог их гүрнүүд тийшээ яагаад хандаад ач холбогдол өгөөд байна вэ гэдгээс хариулт хайя. Энэ бүс нутагт уламжлалт түнш-холбоотон Оросоос гадна, АНУ, Турк, Европын Холбоо, Хятад, Энэтхэгийн ашиг сонирхлууд шууд төвлөрөх хандлагатай болсныг бид бүхэн ажиглаж байна. Төв Ази хэмээх энэ бүс нутаг бол ШХАБ-ын гурван том гигант–Орос, Хятад, Энэтхэгийн нөлөөний хүрээний, ашиг сонирхлын үндсэн талбар мөн бишийн тухай би өгүүлэх гээгүй. Орос бэхжсэн байснаа байр сууриа Хятадад эдийн засгийн хувьд алдах эхлэл тавигдсан. Гэхдээ энэ гурван улсын хэн нь ч нөгөө аль нэгийгээ Төв Азид хэт давамгайлахыг зөвшөөрөхгүй. Иймд Төв Азид хэн нь хэнийгээ вэ гэх далд зөрчил тэмцэл ШХАБ-ын гурван том гүрний дунд бугшиж байна. Үүн дээр Пакистан, Иран хоёр ч ШХАБ дотроо томхон тоглогч болоод гараад ирэх нигуртайг үгүйсгэж болохгүй.

“Төв Ази ба Нэг” (“C5+1”) гэсэн дээд хэмжээний уулзалт-саммитын формат энэ цаг үед тун идэвхтэй төлөвшин байна. Эхлээд ийм үйл явцыг Турк эхлүүлсэн. Тэр ойлгомжтой. Туркээс гадна хоёроос гурван ч том тоглогч ийм форматаар тодрон гарч ирээд өрсөлдөн байна. Төв Ази дахь их гүрнүүдийн өрсөлдөөн Орос-Украины дайны өнгөн дээр бүр ч илэрхий болж байна.

1. Манлайлах тоглогч нь мэдээж АНУ мөн. Анх 2015 онд Самаркандад “C5+1” форматын уулзалтаас эхлэн АНУ ба Төв Азийн 5 улсын хамтын ажиллагаа АНУ-аас санаачилсан энэхүү “C5+1” гэх геополитикийн шинэ төслийн хүрээнд идэвхжсэн. Хамгийн сүүлд Д.Трамп нь Төв Азийн 5 Ерөнхийлөгчийг Цагаан ордондоо урьж аваачин стратегийн хамтын ажиллагааны шинэ үеийг эхлүүллээ. Дэлхийн улс орнуудын дээд лидер нь АНУ ба Трамп хэмээн тэднээр хүлээн зөвшөөрүүлж чадсан нь хамгийн том алхам боллоо, Вашингтоны хувьд. Төв Азийг нөлөөний хүрээнийхээ уламжлалт бүс нутаг хэмээн үздэг ОХУ нь тухайн үед ч, одоо ч огт таатай хандахгүй байна.
2. АНУ-аас юугаар дутах билээ гэсэн шиг БНХАУ нь 2020 онд санаачлан виртуал дээд хэмжээний уулзалт “Хятад-Төв Ази” буюу бас нэг “C5+1” гэдгийг эхлүүлсэн. Хятад нь Төв Азид Туркийн хэмжээний нэр нөлөөтэй, улс төрийн ашиг сонирхолтой нотолгоо хэмээн энэ форматыг үздэг.
3. Түүний дараа Хятадын араас Европын Холбоо энэхүү бүс нутгийн геополитикийн ач холбогдлыг улам өндөрсгөж “C5+1” (Европын холбоо-Төв Ази) уулзалт зохион байгуулсан. 2022 оны 10-р сард Европын Зөвлөлийн ерөнхийлөгч Чарльз Мишель Астана хотноо Төв Азийн 5 удирдагчийн хамт анхдугаар уулзалтаа хийсэн.
4. ОХУ шоок нээнтэгэнд байснаа Мишелийн айлчлалыг дагалдуулан ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин өөрөө санаачлан Астанад яаравчлан очин “ОХУ-Төв Азийн анхдугаар чуулга уулзалт” зохион байгуулсан баримт энд нэгийг хэлэх байх.

* Судлаач-профессор, Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин

Email: bayardevi@hotmail.com

Хоёр. Турк яг одоо Төв Азид

Түрэг хэлтэй улсуудын дээд түвшний анхдугаар уулзалтыг Туркээс санаачлан 1992 онд зохион байгуулснаас хойш бүс нутгийн-иргэншил соёлын хамтын ажиллагааны энхүү байнгын механизм төлөвшиж, Монгол маань ч тэдэнтэй холбогдсон. Түрэг хэлтэй улсуудын хамтын ажиллагааны зөвлөл (Түрэг зөвлөл) нь 2021 онд Түрэг угсааны улсуудын байгууллага болж шинэ шатандаа гарсан. Туркменистаныг ажиглагч гишүүнээр элсүүлж, “Түрэг ертөнц–Алсын хараа 2040” хэмээх түрэг угсааны улсуудын нийтлэг эрх ашгийг хөндсөн стратегийн хөгжлийн баримт бичиг батлан мөрдөж байна.

Украины эсрэг Орос дайтаж, Өрнөдөөс Оросын эсрэг санкц тавьснаас үүдэн Төв Азийнхны өмнө олон шинэ боломжууд гарч ирсэний Турктэй хамтын ажиллагаагаа эрс өсгөж бэхжүүлсэн явдал болно. “Түрэгүүд маш том хүч болох ёстой” хэмээн 2022 оны 11-р сард Түрэг угсааны улсуудын байгууллагын Төрийн тэргүүн нар нэгдсэн дуугаар мэдэгдсэн ба 4 сарын дараа 2023 оны 3-р сард Анкарад Төрийн тэргүүн нар дахин цугларч, ээлжит бус саммитаа хийсэн. Саммит дээр “Түрэгүүд маш том хүч болох ёстой” гэж мэдэгдсэн нь түрэг гарал үүсэлтэй Турк ба Төв Ази, Кавказын улс үндэстнүүд, мөн ОХУ дахь түрэг гаралтай, лалын шашинтай бүс нутгийн хүн ам, мөн Крымын уугуул түрэгүүд, магадгүй Монгол, Хятад дахь түрэг гаралтай хүн ард руу чиглүүлсэн стратегийн уриа дуудлага байсан болов уу.

Түрэгүүд ингэж нэгдэж нягтрахаас аргагүй тийм цаг үе тулгарсан, ялангуяа Орос-Украины дайны фонон дээр хуучин Дундад Азийн түрэг хэлт, түрэг гаралт үндэстнүүд Оросоос учирч мэдэх геополитикийн таагүй сорилтыг урьдчилан сөрөхийн тулд “Их Түрэг”-ийн (Пан-Турк) бодлогын ивээлд багтахыг хичээж буй нь нууц биш юм.

Энэ нь ч бодит учир шалтгаантай. Учир нь ОХУ нь хуучин Дундад Азийг зөнд нь орхих хүсэлгүй, уламжлалт ашиг сонирхлоосоо гаргахгүй явж ирсэн, тэр нь тэр бүр таатай байдаггүйтэй холбоотой. ОХУ-аас хуучин СССР-ийн Дундад Ази руу хандсан хэд хэдэн чиглэлийн бодлого явуулж байх шиг харагддаг. Хэзээ ч сулардаггүй хардлага нь Өрнөдтэй ямагт сөргөлддөг Кремлийн бодлогоос урган гардаг. Эдүгээ АНУ, Европын Холбооноос гадна НАТО-гийн гишүүн Турк Оросын хувьд яаж ч чадахгүй шинэ сорилт болоод байна.

Төв Ази дэлхий дахины хувьд ийнхүү чухал цэг, бүс нутаг болж хувирсан бодит хүчин зүйл манай улсын Төв Азийг харах өнцгийг улам хурцалж өгсөн хэмээн би үздэг.

Гурав. Төв Ази руу хийх Монголын “цөмрөлт”

Эвгүй, эсвэл гэнэтийн огцомдсон үг өгүүлэлдээ авчихлаа. Цөмрөлт гэдгийг англиар challenge гэж дүйцүүлэх гэсэн санаа юм. Сорилт гэх нь хэт даруудаад гэх үү дээ. Хоёр хөрш ба гуравдагч хөршүүд, ерөөсөө дэлхий дахин руу хандуулсан том challenge хэмээн би үзэж байна. Гадаад бодлогын том ололт хэмээн үзсэн. Энэ challenge бол Төв Азийг (хуучнаар Зөвлөлтийн Дундад Ази) тэр чигт хамарсан гэдгээрээ 2024-2025 оны, магадгүй 2026 оны гадаад бодлогын түүхнээ тэмдэглэгдэнэ.

Бидний хувьд Төв Ази бол огт шинээр танигдсан ертөнц биш ээ. Социализмын үед найрамдлын сарын арга хэмжээ зохиогддог (Монголын соёлын өдрүүд, эсвэл Зөвлөлт Тажикистаны соёлын өдрүүд, Зөвлөлт Казахстаны кино 7 хоног гэх мэт), манай оюутан, ТМС-ийн сурагч бэлтгэх уурхай болж байсан ах дүү Зөвлөлтийн Дундад Азийн БНУ-ууд шүү дээ. Тэр бүс нутаг эдүгээ манай гадаад бодлогын чухал чиглэл, бүр тодорхой онож хэлбэл бидэндээ шинээр нээгдсэн гуравдагч хөршүүд болж хувирсныг өнгөрсөн хоёр гуравхан жилийн хоёр талын дээд өндөр түвшний айлчлалууд (Төв Азийн 5 улс+Азербайжан), стратегийн ба иж бүрэн түншлэлийн харилцааг тунхагласан найрсаг гурван улсаас (Казахстан, Узбекистан, Киргизстан) бэлхнээ харж болохоор байна.

Хүснэгт 1. Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн Төв Азийн орнуудад хийсэн айлчлал ба хариу айлчлал

Он	Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн айлчлал	Хариу айлчлал
2022	ШХАБ-ын Төрийн тэргүүн нарын зөвлөлийн XXII хуралдаан (Самарканд, Узбекистан)	
2023		Киргизстаны Ерөнхийлөгч
2024	Узбекистан ШХАБ-ын Төрийн тэргүүн нарын зөвлөлийн XXIV хуралдаан (Казахстан, Астана) Туркменистан Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаархи дэлхийн удирдагчдын дээд түвшний уулзалт ("COP29", Баку, Азербайжан)	Казахтсаны Ерөнхийлөгч (Стратегийн түншлэлийн харилцаа)
2025	Киргизстан (Иж бүрэн түншлэл) Тажикистан	Туркменистаны Ерөнхийлөгч Узбекистаны Ерөнхийлөгч (Иж бүрэн түншлэл)

Төр-засгийн тэргүүн нарын айлчлалын жагсаалтад 2023 онд Ерөнхий сайд Киргизстанд айлчилж, мөн ШХАБ-ын Засгийн газрын тэргүүн нарын Зөвлөлийн өргөтгөсөн XXII хуралдаанд оролцсон, 2024 онд УИХ-ын дарга, Киргиз улсын Жогорку Кенешийн дарга нар харилцан айлчилсан, УИХ-ын дарга 2025 онд Казахстанд айлчилсан нь айлчлалын давтамжийг хадгалахад чухал үүрэгтэй байсныг дурдах хэрэгтэй. Гадаад харилцааны сайдын түвшинд ч харилцан айлчлалууд хэрэгжсээр ирсэн. Шадар сайд, бусад яамдын сайд, ЗГХК-ын хурал зэргийг энд нэмбэл Төв Азийн орнуудтай харилцаа, хамтын ажиллагаа шат шатандаа ахисаар иржээ.

Хүснэгт 2. Гадаад харилцааны сайдын харилцан айлчлал

2021	Казахстан Азид хамтын ажиллагаа, итгэлцлийг бэхжүүлэх бага хурлын Гадаад хэргийн сайд нарын VI уулзалт	
2022	Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний Сайд нарын хурал (Баку)	АХАИББХ-ын Гүйцэтгэх захирал
2023	Узбекистан	Киргиз улсын Гадаад хэргийн сайд
2025		Казахстаны Шадар сайд бөгөөд Гадаад хэргийн сайд

Дөрөв. 2025 оны Төрийн айлчлалын онцлог

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх 2025 оны зун Киргизстан, Тажикистанд Төрийн айлчлал хийхэд ажлын хэсэгт дагалдан явсны хувьд онцлог гэхээр хэд хэдэн зүйл ажиглав. Өмнөх он жилүүдэд манай Төр-засгийн удирдагчид Төрийн айлчлал хийхээр энэ хоёр улсад морилж байгаагүй юм билээ. Тийм учраас анх удаагийн Төрийн айлчлал гэж үзэж болно. “Төрийн” гэдэг тодотголын цаана агуулга нь өргөн дэлгэр, үр дүн нь илүү тод ба шахуу, Монголын улс төр, түүх-соёл урлаг, бизнес-хөрөнгө оруулалт, худалдаа гээд олон салбарыг хамардаг. Хэдхэн өдөрт тэр улсыг “Монголоор амьсгалуулаад” дуусдаг. Тийм уламжлал сүүлийн гурван жилд тогтож байна. Төв Азийн энэ хоёр улсад Монголын маш том сурталчилгаа, танилцуулга, манай ард түмний найрсаг сэтгэлийн илэрхийллийг тээж Төрийн тэргүүн ба дагалдагсад очсон хэмээн онцолж байна.

Гадаад бодлого судлаачийн хувьд энэ удаагийн айлчлалын ба “цөмрөлт” гэсэн утга тээсний цаад учгийг геополитикийн өнцгөөс би олж хараад онцлог гээд байгаа хэрэг. Монгол маань Төв Ази, мөн түрэг хэлт ертөнцөд хэрдээ тохирсон тоглогч болж бэхжиж байгааг зориуд онцлон тэмдэглэхийг хүсч байна. Түрэг хэл-соёлт улсуудын манлайлагч Турктэй 2025 оны эхээр Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Төрийн айлчлал хийхдээ стратегийн түншлэл тогтоосныг дурдахад хангалттай. Бүх салбарт Турк манай гол түншийн нэг болж чадсан.

Тэгвэл Монгол Улс нь Түрэг угсааны улсуудын байгууллагын гишүүн 4 улстай (Турк, Казахстан, Узбекистан, Киргизстан) түншлэлийн харилцаатай, мөн Азербайжан, Туркменистантэй хоёр талын харилцаагаа идэвхтэй хөгжүүлж байна. Хэтдээ түншлэлийн харилцаа төлөвшнө. Бүхэлдээ энэ 6 улстай тогтоосон харилцаа нь ах дүүсэг, харилцан ашигтай, хоёр ард түмэндээ ээлтэй хөгжиж байна. Тэгэхлээр Ерөнхийлөгчийн энэ удаагийн айлчлал бол Түрэг хэлт орнуудын хамтын нийгэмлэг рүү хандуулсан Монголын дипломатын томхон challenge байж болно. Тажикийг яагаад нэрлэхгүй байна вэ гэвэл Түрэг угсааны улсуудын байгууллагын гадна байдаг, түрэг биш өөр угсаа гарвалтай гэдгээр юм. Гэвч Төрийн тэргүүний энэ удаагийн айлчлал, 2026 онд хэрэгжих Тажикистаны Ерөнхийлөгчийн Төрийн айлчлалын үед Иж бүрэн түншлэл тогтооно гэсэн итгэлтэй байна.

Төв Ази нь бүс нутгаараа манай улсын гуравдагч хөрш болж төлөвших замын бэлчир дээр байна. Тун удахгүй тэгж нэрлэгдэх болно. Үндсэндээ Монголын Улсын гадаад бодлогын тэлэлт Төв Азийг ийнхүү хамарснаар Төв Ази дахь бодлого маань бүрэн бүтэн болж буй хэрэг

юм. Төв Ази (хуучнаар Зөвлөлтийн Дундад Ази) руу чиглэсэн бүхэл бүтэн цогц бодлого болж түүхнээ тэмдэглэгдэнэ.

Бүс нутгийн 5 улстай 1992 онд дипломат харилцаа тогтоож албан ёсны харилцаатай, айлчлалууд голдуу нэг урсгалтай (манайхаас түлхүү), Туркменистантай идэвхтэй харилцаагүй явж ирснийг энэ хоёрхон жилд үндсэнд нь “бүрэн бүтэн” болголоо (эх сурвалж–Э.Одбаяр: Тажикистан улсад хийсэн айлчлалаар Монгол Төрийн *Төв Ази* руу чиглэсэн гадаад бодлого *бүрэн бүтэн* болж байна-ikon.mn) гэсэн дүгнэлт бол яг голоор нь олоод хэлчихсэн мэт.

Сайд Б.Батцэцэгийн онож томъёолсноор, Монгол Улсын гадаад бодлогын томоохон зорилтуудын нэг нь Төв Азийн орнуудтай харилцаа, хамтын ажиллагаагаа бэхжүүлэх явдал бөгөөд энэ хугацаанд Төв Азийн 5 улстай маш идэвхтэй гадаад харилцааг цогцлуулсан, Төрийн айлчлал нь харилцааны хамгийн оргил хэсэг. Талууд маш олон жил бэлтгэдэг, судалдаг. Энэ удаагийн айлчлал нь “Нэгнээсээ гуйх биш, нэг нэгнээ хөгжүүлэх харилцан ашигтай хамтын ажиллагааг буй болгох”-ын төлөө байсан ба хоёр орны харилцааны түвшинг ахиулсан хамтарсан тунхаглал мэдэгдлүүд, байгуулсан баримт бичгүүд нь цаашдаа хоёр орны харилцааг илүү хялбаршуулах эрх зүйн боломжийг бүрдүүлсэн, ийм л үр дүнтэй айлчлалууд боллоо гэжээ.

“Төв Азид шан татах цаг нь болсон шүү, амжилт!” хэмээн нэг найз маань бичсэн байсан. “Монгол Улс Төв Азид төдийгүй Евразид эдийн засгийн гарцаа нээснийг тунхагласан айлчлал боллоо” хэмээн манай нэртэй сэтгүүлч baabar.mn сайтад бичсэн. Манай судлаач доктор Х.Баатархүү ингэж дүгнэжээ:–Өрнө Дорныг холбосон өнө эртний түүхт торгоны замын дагуу, геополитикийн нэн чухал байршилд Төв Азийн 5 улс оршиж байгаа энэхүү бүс нутгийг дэлхийн томоохон улс орнууд маш их сонирхож, ач холбогдол өгч, Төв Азийн “Таван улс+” гэсэн формат бүхий түншлэл тогтоож байгаа даян дэлхийн том гүрнүүдийн өрсөлдөөнөөс Монгол Улс хоцроогүй, харин ч идэвхтэй манлайлж буй гэдгээ энэ удаагийн айлчлалаараа илэрхийлж чадлаа гэжээ.

Тав. Зарим дүгнэлт

Өөрийн биеэр хоёр айлчлалаар дүгнэлтээ орлуулъя. Ямар өнцгөөс айлчлалыг дүгнэх вэ гэдэгтээ би хариултаа ингэж буулгаж байна:

- Шинэлэг, бараг цоо шинэ практик гэх үү, үзэгдлийг олж харсан. Жишээ нь Киргизтэй. Ерөнхийлөгч С.Жапаров ба ноён У.Хүрэлсүх нарын хооронд жинхэнэ андлалын харилцаа тогтоов. Ноён Жапаров өөрийн биеэр нисэх онгоцны буудалд манай Төрийн тэргүүнийг угтан авсан, бас үдэж өгсөн. Тус улс анх удаагаа нисэх онгоцны буудалдаа нүүдэлчдийн соёлыг илэрхийлсэн үндэсний гэр барьж, эртний морьт цэргээс бүрдсэн хүндэт харуултай угтан авсан.
- Киргизэд бараг хоёр тусдаа хөтөлбөрөөр (хоёр улсын Ерөнхийлөгч ба хоёр Шадар сайдаар ахлуулсан хоёр улсын төлөөлөгчид) айлчлал хэрэгжлээ. Хоёр улсын Ерөнхийлөгч гурван өдөр хамт байж, илэн далангүй ярилцаж нөхөрлөсөн нь тэр бүр хоёр улсын харилцааны ёслол протоколын практикт байдаггүй үзэгдэл.
- Монгол-Тажикстаны хувьд харьцангуй идэвхтэй биш байсан гадаад харилцаагаа энэ удаа улам идэвхжүүллээ. Тажикистан гэдэг улсыг Монголд, монголчуудад нээж өгсөн айлчлал боллоо.
- Монгол ба монголчуудаа Киргизэд дахин нээж өгсөн бол Тажикистанд шинээр тэгэхдээ томхон далайцтай нээж өглөө.
- “Төрийн айлчлал” гэдэг нь хамгийн дээд түвшний, агуулга нь өргөн дэлгэр, үр дүн нь илүү тод ба шахуу, гэхдээ Монголын улс төр, түүх-соёл, урлаг, бизнес-хөрөнгө оруулалт, худалдаа гээд олон салбарыг хамардаг. Хэдхэн өдөрт тэр улсыг “Монголоор амьсгалуулаад” дуусдаг гэдэг нь ч энэ удаа хоёр улсад харагдаж байлаа.

Төрийн айлчлалд ийм уламжлал ноён У.Хүрэлсүхийн өнгөн дээр төлөвшиж тогтож байна. Тэгээд ч энэ удаа Төв Азийн хоёр улсад Монголын маш том сурталчилгаа, танилцуулга явагдаж, манай ард түмний найрсаг сэтгэлийн илэрхийлэл тэнд мөнхрөн үлдлээ.

Хоёр талын харилцан айлчлалуудаас ажихад Төв Азийн 5 улс бол ТУХН, ШХАБ, Евразийн эдийн засгийн холбоо, ОДКБ эвслийн гишүүд байна. Энэ маань манай улсаас Оростой явуулах хоёр талын харилцаанд ч нөгөө талын тэнцвэржүүлэгч болох магадлалтай. ОХУ-ын зүгээс найрсаг харилцаагаа манай улстай хадгалж байгаа ч геополитикийн эрсдэл-хуваагдлын шинэ нөхцөл байдалд Төв Ази гэж шинэ тэнцвэржүүлэгч ба гуравдагч хөршөө бид олоод авлаа, бэхжүүллээ, цаашаа дурайх зам тодорлоо. Энэ цаг дор Монгол-Өрнөдийн стратегийн түншлэлд хоёр хөрш маань таагүй ханддаг бол Төв Азийн түнш нартаа тэд тэгж хандахгүй. Энэ бол манай гадаад бодлогод тохиох нэг том боломж юм биш үү?

Гол нь нэг том, бүр томоос том ололт бол бидний хувьд Туркийн ба түрэг хэлт ертөнц, исламын ертөнцөд хоёр талын энэ олон айлчлалууд нэмэх оноо авчирна. Түрэг угсааны улсуудын байгууллагын гишүүн 4 улстай (Турк, Казахстан, Узбекистан, Киргизстан) түншлэлийн харилцаатай болчихлоо, исламын шашинт Тажикистантай ийм түншлэл тогтоох нь ойрын ирээдүйд хэрэгжинэ. Тэгэхлээр энэ олон айлчлалууд Түрэг хэлт ба исламын шашинт орнуудын хамтын нийгэмлэг рүү хандуулсан Монголын дипломатын томхон challenge байх болов уу хэмээн үзэж байна.

Манай улс Төв Азид бэхжээд авна гэдэг ерөөсөө гадаад бодлогын түүхэн том ололт мөн. Хятад нь эдийн засгийн хувьд тус бүс нутагт бэхжсээр, барьцаа ахиулсаар байна. Тэр давуу талыг нь ашиглах боломж бидэнд бий. Хятадаар дамжуулан Төв Азитай шууд харилцах шинэ торгоны замын асуудал манай хувьд бодитойгоор босч ирнэ. Ноён С.Жапаровын санаачилга болох “Бишкек-Өрөмч-Улаанбаатар” гэх дэд бүтцийн маршрут маш том боломж байх болов уу.

“Төв Ази ба Нэг” (“C5+1”) гэсэн дээд хэмжээний уулзалт-саммитын формат заавал хөгжилтэй, хүчирхэг орнуудын үзэмж тааллаар төлөвших албатай биш. Энэ асуултыг би тавьдаг, энэ талаар эргэцүүлдэг. Төв Азид улс төр-эдийн засаг, худалдаа, хүмүүнлэгийн ашиг сонирхолтой болж буй манай улсын хувьд хэрдээ тохирсон “C5+1” (Монгол+Төв Ази) формат яагаад буй болгож болохгүй билээ. Түүний төлөө бид яагаад ажиллаж хөөцөлдөж болохгүй билээ. Ирээдүй цаг дээр, алсын алсад мэт төсөөлөгдөж байгаа бол бас ч тийм холын үл бүтэх зүйл биш байх шүү!